

Хятадын ард түмэн олон мянган жилийн түүх соёлтой эртний ард түмнүүдийн нэг билээ. Ялангуяа хятадын уран зохиол нэн эртний баялаг түүхтэй агаад барагцаалбал 3000 гаруй жилийн урт удаан хугацааны туршид зохиогдсоор ирсэн ардын аман зохиол ба бичмэл уран зохиол нь олон талтай, төрөл зүйл, хэлбэр хэмжээний хувьд янз бүр байдаг. Үүний зэрэгцээ Хятадын уран зохиол үндэсний маш их өвөрмөц онцлог шинжүүдтэй, дэлхийн бусад тив, улс орнуудын уран зохиол байтугай дорнодахины улс түмнүүдийн урлаг, уран зохиолын дотор ч үндэсний өвөрмөц шинжээрээ багагүй ялгардаг байна.

Хятадын уран зохиол дорнодахины олон улс үндэстэн, түүний дотор нэн ялангуяа Япон, Солонгос, Вьетнамын уран зохиолын хөгжилд үлэмж нөлөө үзүүлжээ. Тухайлбал, Япончууд: «Японд хятадын урлаг соёлын үзүүлсэн нөлөөг зөвхөн тухайн тодорхой зүйлээр бус, харин бүхэлд нь нөлөөлснөөр авч үзвэл зохино» гэж үздэг ажээ.

Хятадын уран зохиолыг бүхэлд нь гурван үе шат болгон хувааж үздэг. Эдгээр нь эртний хятадын уран зохиол буюу сонгодог уран зохиол, шинэ үеийн уран зохиол, орчин үеийн уран зохиол гэсэн гурван үе шат болно. Үе тус бүр ч дотроо тухайн үеийн нийгмийн хийгээд урлаг соёл утга зохиолын хөгжил цэцэглэлтээс шалтгаалан тодорхой ангилал үечлэлд хуваагддаг байна. Энэ удаад Хятадын уран зохиолын хөгжлийн ерөнхий үе шатуудыг товчхон авч үзье.

**Сонгодог уран зохиол.** Хятадын сонгодог уран зохиол нь Цин улсаас (МЭӨ 221—207 он) бүр өмнөх үеэс 1800 оныг хүртэлх, түүхийн урт удаан хугацааны үеийг хамардаг.

Сонгодог утга зохиол нь дотроо эртний, дундад зууны үеийн гэж хоёр хуваагддаг. Эртний уран зохиол нь хятадын үндэстэн ястны дунд ардын аман зохиол ид цэцэглэн хөгжиж, анх бичиг соёл бий болж эхэлж байсан нэн эртний үеэс феодалын нийгмийн шатанд шилжин орох хүртэл буюу VI—VII зууны үеийг хүртэл хамардаг. Хятадын утга зохиолын хөгжлийн түүх, тэр тусмаа дээрх маягаар ангилан хуваасан үе бүрийн хөгжлийн түүх өөрийн гэсэн онцлог бүхий өвөрмөц шинж чанараараа хоорондоо ялгарч байдаг. Тухайлбал: - Эртний уран зохиолд голчлон сургаал, ёс зүй, гүн ухааны туурвил бүтээлүүд голлодог бөгөөд Күнз, Минз, Моз, Даосын ёсны асар их өв суурь бүтээлүүд нь амьдрах, аж төрөхийн тухай сургаал, ах дүү, амраг садан, эцэг (эх) үр, багш шавийн барилдлагааны элбэрэлт ёс, эрхэм зүй, эцэг болсон тэнгэр, эх болсон газрын үүсэл гарал, түүнтэй холбоотой, түүн дээр оршиж, үүсч мөхөж буй бүхнийг, юм үзэгдлийг хэрхэн үзэж ухаарах тухай дорнодахины гүн ухааны сэтгэлгээний нэг маш өвөрмөц салшгүй хэсэг бөгөөд эртний Жагар, төвдийн гүн ухааны хамт дорнодахины гүн ухааны сэтгэлгээний нэгэн том цогцыг бүрэлдүүлж байна. Өөрөөр хэлбэл хүн төрөлхтний ертөнцийг үзэх өрнө ба дорно дахины хэмээх хоёр том цогцын нэг болох дорнодахины үзлийг энэ гурван хэсэг гүн ухаан бүрэлдүүлж байна гэж үзэж болох юм.

Алдарт «Шүлэглэлт ном» зохиогдсон Баруун Жоу улсын (МЭӨ 11--7-р зуун) үе түүнчлэн, Хавар, Намрын улсын үеийг (МЭӨ 770-- 476 он) 3000 гаруй жилийн түүхтэй хятадын уран зохиолын мэндэлсэн үе гэдэг. «Шүлэглэлт ном» бол хамгийн эртний, төгс төгөлдөр бүтээл бөгөөд 300 гаруй шүлэг дууллыг нэгтгэсэн их түүвэр юм. Эрт цагийн дуулал магтуу, ардын дуу шүлгээс бүтсэн «Шүлэглэлт ном» нь сонгодог сор бүтээлийн зиндаанд хүрч, мянга мянган жилийн туршид хятадын ард түмний амьдралын толь болсоор иржээ. Хятадын уран зохиолын сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр Хятадын их гүн ухаантан Күнз эртний яруу найргийг ихэд ойшоон үнэлж, сэтгэл оюуны асар их чадавхи шингэсэн байгааг нь олж хараад, олонд түгсэн гурван мянга илүү шүлэг найргаас аравны нэг орчмыг нь сонгон шилж эмхэтгэсэн нь энэхүү алдарт бүтээлийг төрүүлсэн ажээ. Гурван зуун таван шүлэг найргийг нэгтгэсэн энэ ном «Төр ёс», «Бага магтуу», «Их магтуу», «Сүлд дуулал» гэсэн дөрвөн бүлгээс бүрддэг. Үнэхээр ч «Шүлэглэлт ном» хятадын яруу найргийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлжээ. Хятадын уран зохиолын түүхэнд олон олон шүлэгч найрагчийн нэр бичигдсэний дотор уран бүтээлд нь «Шүлэглэлт ном»-ын нөлөө аль нэг хэмжээнд шууд ба дам тусаагүй, түүнээс суралцаагүй шүлэгчийг нэрлэхэд хэцүү бизээ. Тиймээс ч хятадын яруу найргийг энэ суут бүтээлээс эх авч соёолсон гэхэд хэтрүүлсэн болохгүй. «Шүлэглэлт ном» бол жир бусын дуу магтуу, шүлгийнхээ үзэл санаа, хэл бичлэг, ер нь байгаа бүхнээрээ жинхэнэ үндэсний шинж төрхтэй уран зохиолын дурсгал юм. Энэ утгаараа ч «Илиада, Одиссей», «Рамаяна», «Махабхарата», «Игорын хорооны тууж», «Гэсэр», «Жангар» зэрэг дэлхийн утга зохиолын сор болсон бүтээлүүдтэй нэгэн зиндаанд хэлцэгддэг байна.

Байлдаант улсын үед (МЭӨ 340--278 он) их яруу найрагч, эх оронч Цюй Юань, өөрийн алдарт «Ли Сао» болон бусад шүлэг найргаа туурвин, хятадын уран зохиолын анхны оргил болон мөнхөжсөн юм. Цюй Юань бол хятадын утга зохиолын түүхэн дэх анхны том уран бүтээлч, суут сэтгэгч, улс төрийн зүтгэлтэн хүн юм. Цюй Юаны зохиол бүтээлээс эдүгээ уламжлагдаж ирсэн нь 25 шүлэг найраг бий бөгөөд хамгийн алдартай нь Ли Сао хэмээх юм. Хятадын сонгодог яруу найргийн дотроос хамгийн урт уянгын найраг болох энэ бүтээл 373 шад 2477 үгтэй бөгөөд найрагчийн үзэл бодол, гүн ухааны сэтгэлгээ, сайн муу, сайхан муухайгийн ёс зүй, эх орон, ард түмнээ хайрлах сэтгэлийн яруу дуулал юм. Үүгээрээ энэ дуулал хятадын сонгодог яруу найргийн нэг ноён оргил болж, хятадын уран зохиолын түүхэнд гүн гүнзгий нөлөө, ул мөрөө үлдээсэн байна.

Вэй, Зинь (МЭ 220—420 он) улсын үед яруу найраг цэцэглэн хөгжжээ. Цао Цао, Сао, Жи, Руань Зи, Зи Кан нар тухайн үеийнхээ бичгийн их хүмүүс байсан бөгөөд Тао Юаньминь гэгч шүлэг найргаараа онцгой ялгарч байлаа. Өмнөд хийгээд Умард хаанчлалын үе ардын аман зохиол, дуу хуураараа алдартай юм. Өмнөд хаанчлалын үед хайр сэтгэлийн уянга онцгой байсан бол умардын үед ард түмний хүсэл сэтгэлийг илэрхийлсэн дуу хуур уран зохиолын чиглэлийг тодорхойлж байв.

Тан улсын үе (618—907 он) бол хятадын эдийн засаг, соёл үлэмж их цэцэглэн хөгжсөн үе болно. Энэ үеийн уран зохиол, ялангуяа яруу найраг хятадын түүхэнд мандан бадралын туйлдаа хүрсэн бөгөөд тэгээд ч «яруу найргийн алтан үе» гэж зүй ёсоор нэрлэгддэг байна.

Дайчин улсын тэнгэрийг тэтгэсний үед «Тан улсын шүлэг гурван зуун бадаг» хэмээх шилдэг шүлэг найргийн түүвэр гарсан нь хятадын

яруу найргийн алтан үеийн сор бүтээлүүд хойч үед хүрэх чухам зохистой нэгэн хэлбэрийг үүсгэжээ. Мөн үед гарсан «Тан улсын бүрэн шүлэг» хэмээх түүвэрт хоёр мянга гурван зуу гаруй шүлэгч найрагчдын 49 мянга орчим бадаг шүлгийг багтаасан байна. Түүнээс хойш Тан улсын шүлэг найргийг хэд хэдэн янзаар «Гурван зуун бадаг» болгон сонгон түүвэрлэж ирснээс үүдэн: «Тан улсын шүлэг турван зуун бадгийг тагнайдаа тагштал уншвал таг хоосон хүн ч шүлэглэж чаддаг болно» гэсэн зүйр үг дэлгэрсэн гэдэг. Энэ үеийн шүлэг найргийн утга агуулга, төрөл сэдэв нь маш олон янз баялаг өргөн хүрээтэй байдаг. Тухайлбал нийгмийн бүрхэг харанхуй байдал, ард түмний зовлон зүдгүүрт амьдралыг дүрсэлж эх нутаг, байгалийн сайхныг магтан дуулж, дайн самууныг жигшин зэвүүрхэж, энх тунх зол жаргалтай аж төрлийг хүсэн мөрөөдсөн, хайр сэтгэлийг уянгалан дуулсан зэрэг хамгийн өргөн сэдвийг хамарсан байдаг. Тан, Сунгийн үеийн хятадын яруу найраг ийнхүү цэцэглэн хөгжиж урьд хожид ч хүрээгүй оргил туйлд хүрсэн нь зөвхөн хятадын төдийгүй дэлхий дахины урлаг соёлын ертөнцөд тод нэгэн үзэгдэл болон гэрэлт мөр үлдээсэн билээ. Тэдний дотор Ли Бай, Дуфу хоёрын нэр хамгийн алдартай болохыг манай уншигчид сайн мэдэх буй заа.

Ци хэмээх романс буюу уянгал дуу хөгжмийн нөлөөгөөр, харилцан адилгүй үе гишгэдэлтэй мөр шад бүхий яруу найргийн хэлбэр Тан улсын дунд үед үүссэн бөгөөд улмаар Сун улсын (960—1279) үед гүйцэд төгөлдөржин хөгжсөн байна. Энэхүү Ци хэлбэрийн гол төлөөлөгчид нь Лю Юн, Ли Цинжао, Су Ши, Синь Цизи нар юм. Дундад зууны үеийн уран зохиолын нийт төрөл зүйлийн дотор яруу найраг чухал хүндтэй байр эзэлнэ. Тэр үеийн яруу найргийн төрөл зүйлүүдээс «Ци» хэмээх уянгын шүлэглэл онцгой байртай. Энэ бол европ дахины романстай төстэй бөгөөд хайр сэтгэл, байгалийн үзэсгэлэнт сайхан, хайртай хүн, төрөлх нутаг тосгоноо мөрөөсөн дуулсан уянгын шүлгийн төрөл юм. Заримдаа түүнийг уянгал дуу гэж нэрлэх нь ч бий. «Ци» шүлэг бүр Тан улсын үед ч үзэгдэж байсан боловч хятадад том том хот суурин бий болж, хүн ам бөөгнөрөн суурьших явц хүчтэй хөгжсөн нэлээд хожуу үед ихэд тархах болсон нь тодорхой учир шалтгаантай юм. Чухамхүү тэр үед хот суурин газраар тэнүүчлэн тоглож явдаг нүүдлийн дуучин жүжигчид «Ци» шүлгийн анхны зохиогчид байв. Энэ шүлгийн эх үндэс нь ардын дуу ажээ. Анх Ци шүлгийг тодорхой санаа сэдлэгт тулгуурлан бичиж аялгуулан хэлдэг (дуулдаг) байв. Утга төгссөн хоёр, гурав, түүнээс олон мөр шад бүхий бүхэлдээ тодорхой нэг агуулгын илэрхийлэл болсон хэм хэмжээ нь харилцан адилгүй, аялгуундаа тааруулсан урт богино мөр шадтай, дахилт давталттай, хэмнэл аялгаар баялаг байдаг нь түүний нэг онцлог юм.

Сун улсын үед үргэлжилсэн үг, яруу найргийн алдартай олон зохиолчид байснаас дурдвал Ван Аньши, Су Ши, Люй Ю нар онцгой байлаа. Су Сунь, Суши, Сужэ, Оу Янсю, Вань Аньши, Зен Гун нарыг Тан улсын Хан Юй, Лю Зунюань нарын хамт «Тан, Сун улсын найман их эсээчид» гэдэг.

За зүй буюу хөгжимт жүжиг Юан улсын үеийн (1271—1368) уран зохиолын хамгийн том ололт болжээ. Тийм ч учраас энэ үеийг жүжгийн урлагийн алтан үе гэдэг юм. Энэ хөгжимт жүжгийн төрөл нийслэл Даду (эдүгээгийн Бээжин хот) болон Ханжоу нутгаас түгэн дэлгэрч, улмаар хожуу үеүдийн жүжиг бичих, дэглэх, түүнчлэн дуулалт жүжгийн олон төрөлд нөлөө үзүүлсэн юм. Нийслэл Даду бол Монголын их гүрний Юан улсын нийслэл байсан бөгөөд тухайн үед ноёрхож

байсан монголын эзлэн түрэмгийлэгчдийн санаа зоргоор дарлагдагч улс түмний соёл урлаг мандан буурч, хөгжлийн үе шатыг дамжин янз бүрийн төрөл хэлбэрийг олж байсныг дурдах ёстой.

345 зазуй жүжиг уламжлагдан ирсний 63-ыг нь алдарт жүжгийн зохиолч Гуан Ханцин туурвижээ. Түүний «Зун орсон цас», Ван Шифугийн «Баруун танхим» жүжгүүд зуу зуун жилийн турш уншигч, үзэгчдийн хүртээл болж ирсэн шилдэг бүтээлүүд юм.

Мин улс (1368—1644) Цин улс (1644—1911)-ын үе бол жүжгийн уран бүтээлийн дуулиант үеүд байлаа. Тао Миний «Лимбийн аялгуу» Тан Сянзугийн «Мандарваат асар» жүжгүүд Мин улсын алдарт бүтээлүүд болох бол, Зун Шаньрэний «Тоорын цэцгийн хошигнол», Хун Шэнгийн «Мөнх залуу насны ордон» жүжгүүд Цин улсын алдарт бүтээлүүд юм.

Сун, Юан улсын үеийн өгүүллэг бичлэгээс үүсгэлтэй том хэмжээний үргэлжилсэн үгийн зохиол-роман ихээхэн дэлгэрч байлаа. Мин улсын үед Луо Гуанжуны «Гурван улсын үлгэр», Ү Чэньэний «Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл», Сяо Сяошэнгийн «Зинь Пинмэй» буюу «Алтан ваартай сарнай» зэрэг зохиол гарсан нь роман бичлэг цэцэглэн хөгжиж байсныг илтгэнэ.

Дундад зууны үеийн уран зохиол бол сонгодог уран зохиолын хөгжлийн хоёр дахь үе бөгөөд VI—XIX зууны урт удаан хугацааг хамардаг. Энэ үеийн уран зохиолын онцлог шинж бол юуны өмнө далдын ид шид, ер бусын их хүч, жигтэй сонин хачин юмсын тухай өгүүлэмж юм. Хятадын тухайн үеийн хэл шинжээчдээс, хүүрнэл зохиолын холбогдох төрөлд оноосон нэр болох чуаньци буюу гайхамшигт сонин тухай өгүүлдэг зохиол бүтээлүүдээс ч үүнийг үзэж болно. Тэгээд ч тийм зохиолын байнгын дүрүүд нь ёст мэт үнэгэн сүнс (хувилгаан үнэг), буг чөтгөр, дагинас, луу зэрэг ер бусын «амьтас» байдаг аж. Энэ төрөл зүйл нь VII—VIII зууны үеийн шидэт үлгэрүүдтэй гарал нэгтэй бөгөөд түүхийн тодорхой үйл явдал, домог хууч, шог хошин ярианд дулдуйдан бичигдсэн байдаг. Ер нь Мин улсын үед эрчимтэй хөгжиж эхэлсэн роман бичлэг Цин улсын үед дээд туйлдаа хүрсэн бөгөөд энэ үеийг роман туурвилын алтан үе гэдэг. Цин улсын үед V Зиндыгийн хошигнолт роман «Эрдэмт мэргэд», Цао Сюэциний шилдэг бүтээл болсон «Улаан асрын зүүд» роман гарчээ. «Улаан асрын зүүд» бол хятадын сонгодог уран зохиолын реалист зохиол бүтээлийн суут нь бөгөөд дэлхий дахинаа алдартай юм. Энэ зохиолд дээд угсаатай язгууртан гэр бүлийн мандал буурал, тэдний нийтлэг дүр төрхийг нарийн чамбай дүрслэн, чингэснээрээ Хятад дахь ялзарч зэвэрсэн феодалын нийгмийн мөн чанарт шүүмжлэлтэй хатуу ширүүн дүн шинжилгээ хийсэн юм. Пу Сунлингийн богино өгүүллэгийн түүвэр «Ляо Жай жи и» буюу гайхамшигт сонин юмсын тухай үлгэрүүдийг нэгтгэсэн «Ляо Жайн их бичиг» нь мөн Цин улсын үеийн алдартай бүтээлүүдийн тоонд ордог. Энэ зохиолыг буг чөтгөр, «үнэгэн сүнс»-ний тухай домог үлгэрүүдээс сэдэвлэн бичжээ. Үүгээрээ зохиолч, өөрийн аж төрж асан нийгмийн «буг чөтгөр» бологсдыг адилтган элэглэн бичсэн байдаг.

Тан улсын үед аж төрж асан бурхны шашны лам Сюаньзангийн, Энэтхэг хийгээд баруун зүгийн бусад оронд зорчсон 17 жилийн аялал У Чэньэний «Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл» зөгнөлт романы эх материал болсон байна. Олон зуун жил өнгөрөхөд Сюаньзан ламын аялал ардын аман зохиолын дээж болсоор У Чэньэний аж төрж асан үед «Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл» хэмээх энэхүү гайхамшигт

роман болон бүтсэн ажээ. Уран бүтээлийн хошин шог хэлбэр тэр үеийн ангийн зөрчил тэмцлийн дэвшилт зэвсэг болж байсан ба энэ роман ч үүний нэг тод жишээ болдог юм.

**Шинэ үеийн уран зохиол.** 1800 оноос 1919 оны 5 дугаар сарын 4 ний хөдөлгөөнийг хүртэлх үеийг хятадын шинэ үеийн уран зохиолд хамруулдаг. Энэ үеийн зохиол бүтээлүүд тухайн цаг үеийн улс төрийн олон үйл явдал, зөрчил мөргөлдөөн, нийгмийн амьдралын олон талт явдлуудыг тод томруун тусгасан байдаг. Гадаадын түрэмгийлэгчдийн түрэмгий довтолгооныг эсэргүүцэж феодалын нийгмийн ялзарч мөхөх хувь тавиланг дүрслэн илэрхийлж байснаараа энэ үеийн олон зохиол бүтээл дэвшилт үүрэг гүйцэтгэсэн юм.

Энэ үеийн хамгийн нэртэй яруу найрагчдын тоонд Гун Зыжэн (1792—1841) Хуан Зуньсянь (1849-1905) Лю Язы (1887—1958) нар орно. Мөн мянга гаруй алдартай роман тууж энэ үед бичигдсэн байна. Тэдгээрийн дотор «шүүмжлэлт дөрвөн их роман» гэгддэг Ү Зянрэний «Улирсан хорин жилийн жигтэй сонин учралууд», Лю Езгийн «Дереликт ноёны жуулчлал», Зэнпугийн «Синь далайн цэцэг» роман тус тус гарчээ. Гадаад ертөнцтэй харилцаа холбоо өргөжихийн хирээр хятад хэл рүү гадаадын уран зохиолыг орчуулах явдал улам өргөжиж байлаа. Энэ үед Ян Фу (1853—1921), Лин Шу (1852—1924) нар тэргүүлэх гарамгай орчуулагчид байсан бөгөөд тэдний адил бусад олон орчуулагчдын хүчээр мянга орчим зохиол орчуулагдсан нь хятадын уран зохиолын цаашдын хөгжилд зохих нөлөө үзүүлжээ.

### **Орчин үеийн уран зохиолын өрнөл, хөгжил**

Орчин үеийн уран зохиол нь дотроо хувьсгалт уран зохиол (1919—1949 он) шинэ үеийн уран зохиол (1949—1979 он) нэн шинэ үеийн уран зохиол (1979 оноос хойш) гэж гурван дэд үед хуваагддаг. 1919 оны 5 дугаар сарын 4-нд империализм, феодализмыг эсэргүүцсэн хувьсгалт хөдөлгөөн хятад орон даяар өрнөв. Энэхүү бослого тэмцлийн гол зорилго нь Күнзийн суртлыг халж, шинжлэх ухаан, ардчилал, урлаг уран зохиолыг дэлгэрүүлэн хөгжүүлэх явдал байсан агаад чингэснээрээ уран зохиолын шинэ урсгал, хөдөлгөөний үүсэл дэвшилд шууд нөлөөлсөн юм. Хятадын соёлын хувьсгалт хөгжил дэвшлийн гол төлөөлөгч Лу Суний (1881—1936) уран бүтээл энэхүү хөдөлгөөний тулгын чулуу нь болсон билээ. Шүүмжлэлт реализмын шинж чанар бүхий богино хэмжээний өгүүллэгийн түүвэр эмхэтгэлүүд нь тухайн үеийн феодалын нийгмийн жинхэнэ мөн чанарыг илчлэн, хайр найргүй шүүмжлэн яллаж байлаа. Түүний «А Кьюгийн үнэн түүх» өгүүллэг нь хятадын шинэ уран зохиолын түүхэн дэх мөнхийн бүтээл болсон төдийгүй дэлхий дахинаа түгэн алдаршсан байна. Түүнчлэн Гуо Моруогийн (1892—1978) зохиолууд энэ үеийн яруу найргийн шилдэг бүтээлд тооцогддог юм.

1921 онд Хятадын Коммунист Нам байгуулагдсанаар пролетари нар уран зохиолын шинэ хөдөлгөөнийг тэргүүлэх болов. Үүний нэг тод жишээ бол ХКН-ын гишүүн Цюй Цюбай, Дэң Жунся нар 1923 онд бусад нөхдийн хамт хувьсгалт уран зохиолыг идэвхтэй сурталчилж байсан ба 1926 онд Гуо Моруо энэ сэдвээр дахин бичих болсон юм. Соёлын талбар дахь Гоминьдан намын эсэргүү хүчнийхний түрэмгий бодлогын эсрэг дэвшилт зохиолчдын хүчийг нэгтгэх үүднээс 1930 онд ХКН-аар удирдуулсан зүүний зохиолчдын Холбоо байгуулагдаж, хувьсгалт уран зохиолын сар тутмын тогтмол хэвлэл бий болжээ. Энэ үед

Лу Сунь хувьсгалын эсэргүү нарын эсрэг гол цогцтой нийтлэлүүдээрээ эвлэршгүй ширүүн тэмцэл явуулж, Хятадын соёлын хувьсгалт хөгжилтийн алдар суут нь болж байсан юм. Бусад томоохон бүтээлүүдээс дурдвал Мао Дуний (1896—1981) «Үнэгэн харанхуйд», Лао Шэгийн (1899—1966) «Тэмээн сянз», Ба Зиний (1904—1986) «Гэр бүл хавар намар» гурамсан роман, Тянь Ханий «Аянга» жүжгүүд, Ай Цин, Жан Қэзя нарын яруу найргийг нэрлэх нь зүй ёсны хэрэг билээ. 1940-өөд оны үеэс урлаг, уран зохиол бол ард түмэнд, юуны өмнө ажилчин тариачин, цэрэг байлдагчдад үйлчлэх ёстой гэж үзэж, тэдгээрийн хоорондын холбоог бий болгоход ихэд анхаарч Хятадын пролетарийн урлаг, утга зохиолын шинэ эрин үе эхэллээ гэж тэмдэглэж байсан ба зохиолчид, уран бүтээлчид олон түмний дунд орж, тэдний амьдралтай биечлэн танилцаж, суралцаж байлаа. Үүний дунд олон олон шилдэг уран бүтээл бий болсноос Жао Шулигийн «Хэй хөвгүүн хуримласан нь» роман, Ли Юцайгийн шүлгүүд, Ли Зигийн «Ван Гуй, Ли Сяньсянь хоёр» хэмээх том хэмжээний найраглал, Хэ Зинжи, Ди И нарын «Буурал үст бүсгүй» жүжгийг дурдахад хангалттай.

1949 оны 10 дугаар сард БНХАУ байгуулагдсанаас хойш олон шилдэг бүтээл гарав. Тухайлбал Ли Цингийн «Шинэ амьдрал байгуулагчид, Жоу Либогийн «Уулын тосгоны их шинэчлэл», Жао Шулигийн «Санливан тосгон», Ай Үгийн хэд хэдэн роман гарлаа. Өсөх ирээдүйтэй олон сайн залуу зохиолчид, зохиол бүтээлийнхээ хамт уран бүтээлийн их замд орж ирэв. Тэд бол Лян Бин, Ян Мао, Луо Гуанбин болон бусад олон залуу уран бүтээлчид юм. Ай Цин, Ли Зи, Вэн Зе, Гуо Зячуань, Хэ Зинжи нар болон бусад олон нэр цуутай яруу найрагчид олноор төрөн гарч байгаа нь хятадын уран зохиолын олон зуун жилийн түүхэнд байгаагүй онцлог үзэгдэл болж байна. Өнөөдөр хятадад уран зохиолын 400 гаруй тогтмол хэвлэл хэвлэгдэж, тэдгээрт уран зохиолын бүх төрлөөр, хамгийн өргөн хүрээтэй баялаг сэдвүүдээр олон зуун зохиол бүтээл гарч, уншигчдад үйлчилж байна. Хятад орон даяар нийгмийн амьдралын бүх салбарт өөрчлөн байгуулалтыг хийж ирсэн сүүлийн арван жил бол хятадын уран зохиолын замналд ч мөн адил тусч, түүнийг өөрчлөн шинэчилж, тэгснээрээ уран зохиолыг өөрчлөн байгуулалтын хүчирхэг зэвсэг болгон хятадын тэрбум ард түмний оюун санаанд «жинхэнэ соёлын их хувьсгал» хийж байна. Хэдийгээр аравхан жилийн хугацааг хамарч байгаа боловч энэ үе бол олныг хамарсан эрч далайц, онцлог агуулгаараа өмнөх бусад үеүдээс ялгарч байгаа юм.

Хэдэн арван жилийн туршид зөвхөн улс төрийн бодлогын зэвсэг болж ирсэн уран зохиол чухам энэ үеэс л өөрийн жинхэнэ дүр төрх, үндсэн шинж чанартаа эргэн орж зохиолч, яруу найрагчид зөвхөн улс төрийн асуудлыг уран бүтээлийнхээ сэдэв болгохын зэрэгцээ уран зохиолын байр сууринаас хандаж сэдэв сонгох, зохиол бүтээл туурвих, үнэлж цэгнэх боллоо. Ялангуяа яруу найраг магтаал, сургаалын аястай түүхэн уламжлалаасаа сугаран гарч, амьдралыг шинээр нээж, олон талаас нь сэдвийн хувьд өргөн хүрээнд бичих боллоо. Бичлэгийн арга хэлбэр ч нэмэгдэн баяжиж реализм, романтизмын уламжлалт хэлбэрээс гадна уран зохиолын бусад хэлбэр, урсгал, чиглэлүүдээр ч туурвих болов. Тухайлбал импрессионизм, сюрреализмын чиглэлүүд хэдийн бий болж, тэр ч байтугай үндэсний гэх шинэ урсгал чиглэл ч бий болгох гэсэн оролдлого идэвхжиж байна. Зохиолч, яруу найрагчид өөрсдийн сэтгэл зүрхний дуудлагаар уран бүтээлээ чөлөөтэй, урьд өмнө байгаагүй их зориг эрмэлзэл гарган туурвиж байна. Хята-

дын уран зохиолд ийнхүү мандал бадрал, идэвхжлийн их хүч «урам» хайрласан өөрчлөлт шинэчлэлийн бодлого нэг ёсондоо «Зуун цэцэг дэлгэрч, зуун эрдэмтэн уралдаг» гэсэн түүхт уриа дахин цуурайтаж, олон мянган уран бүтээлчийн бүтээлч идэвх, их хүслийг оргилуулсан хэрэг юм. Өнөөдөр тэд энэ уриа дахин муу уршиг, гамшиг зовлон авчрахгүй гэж баттай итгэж, байдаг дуу хоолойгоороо эх орон, ард түмнээ, хятадын онцлогтой социалист бүтээн байгуулалтаа магтан дуулж байна.

Гэвч хятад дахь нээлттэй бодлогын сайн үр дагаврын сацуу саар юм ч байгаагийн нэг адил уран зохиолд хөрөнгөтний уран зохиолын хэт чөлөөтэй уур амьсгал ч нөлөөгөө тусгаж, элдэв алаан хядаан, аймшиг айдас, хүчирхийллийг дүрсэлсэн адал явдал голчлон уншигчдыг хоосон шохоорхол, өнгөц сонирхол руу хөтөлж байгаагаас уран зохиолын цаашдын хөгжилд ээдрээтэй үзэгдлүүд бий болж буйг дурдах ёстой бизээ.